



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/105

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын батлан хамгаалах зарим чиг үүргийг Ховд аймагт төлөөлөн хэрэгжүүлэхээр Батлан хамгаалахын сайдтай байгуулсан гэрээний 1.6, 1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 103 жилийн ой, Халх голын ялалтын 85 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд хүүхэд, залуучуудад цэрэг эх-оронч үзэл төлөвшүүлэх, дайнд оролцсон ахмад дайчдын үйл хэргийг сурталчлах чиглэлээр Ховд аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулж явуулах уралдаан, тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганболд (Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Г.Жавзанхорлоо (Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл, урлаг, биеийн тамир, спортын асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ч.Түмэндэмбэрэл (Биеийн тамир, спортын газрын дарга)

В.Сайнбаяр (Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

М.Пүрэвхүү (Соёл, урлагийн газрын дарга)

Х.Энхболд (Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч, хурандаа)

Т.Жавхланням (Хөгжимт драмын театрын дарга)

8400001 0212
Zah/A/105 Ba

Нарийн бичгийн дарга: Б.Ганхуяг (Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа)

2. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 103 жилийн ой, Халх голын ялалтын 85 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө гарган, удирдлага зохион байгуулалтаар хангаж, чанарын өндөр түвшинд зохион байгуулж, тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Ганболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Х.БАТБОЛД